



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

АЙМАГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН



Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийн нийт эх үүсвэрийн 90,2 хувь нь хугацаа хэтэрсэн авлага хэлбэрт шилжсэн байна.

Сүхбаатар сум 2016 он

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын харьяа

Сэлэнгэ аймгийн

Аудитын газар

Тэргүүлэх аудитор

Ч.Энхтуяа

Аудитор

Ц.Отгонбаяр

2016 оны 06 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70363047,
70363036 дугаарын утас,
70363040 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ:Сэлэнгэ аймгийн
Сүхбаатар сум аймгийн
ЗДТГ-ын байрны
Өргөтгөлд

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт 1
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур
үзүүлэлтүүд 2

**1. Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт,
хуваарилалт оновчтой, үр нөлөөтэй байгаа эсэх?**

- 1.1 Аймаг хөгжүүлэх сангийн журмыг холбогдох хууль, эрх
зүйн актын хүрээнд боловсруулан мөрдөж байна уу?
1.2 Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт,
хуваарилалт оновчтой байна уу?

**2. Аймаг хөгжүүлэх сангаас олгож буй зээлийг үр
ашигтай зарцуулж байна уу?**

- 2.1 Олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж байна уу?
2.2 Зээлийн эргэн төлөлт гэрээт хугацаандаа хийгдэж
байгаа эсэх?
2.3 Аймаг хөгжүүлэх сангийн үр дүнд үнэлэлт, дүгнэлт
өгөгдөж, дотоод хяналт хийгдэж байна уу?

Илрүүлсэн зөрчил

Аудитын дүгнэлт

Холбогдох байгууллагын санал

Саналд өгсөн тайлбар

Зөвлөмж

Хавсралт 1. 2009-2012 онд зээл авсан иргэдийн судалгаа

Хавралт 2. АХС-аас зээл аваад төлөлт огт хийгээгүй иргэдийн
судалгаа

Хавсралт 3. 10,0 сая төгрөгөөс дээш үлдэгдэлтэй зээлдэгчдийн
судалгаа

Хавсралт 4. Шүүхэд шилжүүлээгүй хугацаа хэтэрсэн зээлийн
судалгаа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АХС	Аймаг хөгжүүлэх сан
ГА	Гүйцэтгэлийн аудит
МУ	Монгол улс
ИТХТ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СЭАГ	Сэлэнгэ аймгийн Аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
УИХ	Улсын Их Хурал

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Аймаг хөгжүүлэх сангаас олгосон зээл, түүний эргэн төлөлт, зарцуулалтын үр дүн, үр нөлөөт байдлыг шалган дүгнэлт, зөвлөмж өгч, дүнг холбогдох албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд гүйцэтгэлийн аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- *Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт оновчтой, үр нөлөөтэй байгаа эсэх?*
- *Аймаг хөгжүүлэх сангаас олгож буй зээлийг үр ашигтай зарцуулж байна уу?*

Хамарсан хүрээ, арга зүй

Аудитад 2009 онд Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан нэртэйгээр байгуулагдсан Аймаг хөгжүүлэх сангийн 2009-2016 оны эхний 6 сарын орлого, зарлага, тус сангаас олгосон зээл, түүний эргэн төлөлтийн байдлыг хамруулав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС-3000-3001/-ийг ашиглан холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, нөхцөл байдлын шинжилгээ, түүвэр судалгаа хийх зэргээр нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, Аймгийн ИТХ-ын 2013 оны 26, 2014 оны 47 дугаар тогтоолууд, холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Ц.Отгонбаяр объект дээрх үе шатны ажлыг 2016 оны 9 дүгээр сарын 8-наас 11-р дүгээр сарын 15-ны хооронд, тайлагналын үе шатны ажлыг 12 дугаар сарын 10 наас 12-р сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Анх 2009 онд байгуулагдсан Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн журамд Аймгийн ИТХ-ын 2014 оны 47 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, “Аймаг хөгжүүлэх сан”-гийн журмыг шинэчлэн баталжээ.

Тус санд УИХ-ын гишүүдийн тойрогтоо зарцуулах санхүүжилтээс 2009 онд 1,500.0 сая төгрөг, 2010 онд 990.0 сая төгрөг, 2012 онд 1,900.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 2011 онд 1,000.0 сая төгрөг зэрэг нийт 5,390.0 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна.

Аймаг хөгжүүлэх сан нь 2009-2012 онд “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан” нэртэйгээр зохион байгуулагдаж байсан хугацаанд жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 276 иргэн, аж ахуйн нэгжид 5,287.6 сая төгрөгийн зээлийг хүүгүй, 3 жилийн хугацаатай олгосноос 142 иргэн, аж ахуйн нэгжийн 3,165.3 сая төгрөгийн зээл төлөгдөж, 134 иргэн, аж ахуйн нэгжийн 2,122.3 сая төгрөгийн буюу 40,1 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байна.

Аймаг хөгжүүлэх сангаас 2013-2016 онд залуу гэр бүлд зориулсан орон сууц барих ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор 5 аж ахуйн нэгжид 2,270.0 сая төгрөгийн зээлийг хүүгүй, 1 жилийн хугацаатай олгосноос 4 аж ахуйн нэгжийн 1,970.0 сая төгрөгийн зээл эргэн төлөгдөх хугацаа хэтрээд байна.

Бүлэг 1

Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт оновчтой, үр нөлөөтэй байгаа эсэх?

Холбогдох хууль, эрхийн актуудыг зөрчсөн журмаар зохицуулагдаж буй Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийн 20,0 хүртэл хувийг тухайн жилийн төсөвт тусгагдаж, батлагдаагүй урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болгон ашиглаж байна.

1.1 Аймаг хөгжүүлэх сангийн журмыг холбогдох хууль эрх зүйн актын хүрээнд боловсруулан мөрдөж байна уу?

Аймгийн ИТХ-аас баталсан “Аймаг хөгжүүлэх сан”-гийн журам нь Төсвийн тухай болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудыг зөрчиж байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 20 дугаар зүйлийн 20.1, 18 дугаар зүйлийн 18. 2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн ИТХТ-ийн 2009 оны 02 дугаар тогтоолоор “Аймгийн хөгжлийг дэмжих сан”-г анх байгуулсан байна.

Үүнээс хойш аймгийн ИТХ, түүний тэргүүлэгчдийн дараах тогтоолуудаар журамд өөрчлөлт оруулжээ. Үүнд:

- Аймгийн ИТХТ-дийн 2010 оны 95 дугаар тогтоолоор аймгийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн үйл ажиллагааны журам”-ыг,
- Аймгийн ИТХ-ын 2013 оны 26 дугаар тогтоолоор “Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ыг,
- Аймгийн ИТХ-ын 2014 оны 47 дугаар тогтоолоор “Аймгийн хөгжлийн сан”-г “Аймаг хөгжүүлэх сан” болгон өөрчилж журмыг өөрчлөн баталсан байна. Журмын 3.4.2 “Аймгийн хэмжээнд тэмдэглэх аймаг, сумын ойн арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх”, 3.4.4 “Гадаад харилцаа, хамтын ажиллагааны ажил, үйлчилгээний

зардалд дэмжлэг үзүүлэх” гэж өөрчлөлт оруулснаар урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болгон ашиглах нөхцөл бүрджээ.

- Аймгийн ИТХ-ийн 2016 оны 47 дугаар тогтоолоор “Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлд 3.4.5 “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилах тайлагнахад дэмжлэг үзүүлэх” гэсэн буюу тухайн үеийн дутагдсан санхүүжилт, төсвийн цоорхойг нөхөх зорилгоор өөрчлөлт оруулсан байна.

Аймгийн ИТХТ-дийн 2009 оны 02-р тогтоолоор байгуулагдсан аймгийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан”-гийн хөрөнгө нь:

- Сангаас олгосон зээлийн буцаан төлөлтийн орлого,
- Сангаас олгосон зээлийн хүүгийн орлого, алданги,
- Хуульд заасан бусад эх үүсвэрээс бүрдэхээр журамлагдаж байсан бол

Аймгийн ИТХ-ийн 2013 оны 26-р тогтоолоор “Аймгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгийг дээрхээс гадна дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр заажээ.Үүнд:

- Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж,
- Гадаадын тусламжийн мөнгөн хөрөнгө, тоног төхөөрөмж, бараа материал, бусад эд зүйлийг борлуулснаас олох орлого,

2014 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.2 дахь “Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. 60.2.5 тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж” гэсэн заалтаар гадаад дотоодын хандив тусламж нь ОНХС-д төвлөрөхөөр хуульчлагдсан атал уг заалтыг зөрчин Аймгийн хөгжлийн санд төвлөрүүлэхээр тогтоож, хуулиас давсан журам боловсруулсан байна.

Төсвийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.4 –д “Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж заасан байдаг бөгөөд уг хуулиар зөвхөн Орон нутгийн хөгжлийн санг байгуулж, зарцуулах харилцааг зохицуулсан буюу бусад ямар нэгэн сан байгуулах хууль, эрх зүйн үндэслэл үгүй болно.

Нөгөө талаас, төсөв, санхүүгийн харилцааг зөвхөн Төсвийн тухай хууль, түүнтэй холбогдсон бусад шийдвэрээр зохицуулах хуулийн шаардлагад нийцүүлэн УИХ-аас 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 в “орон нутгийн төсвийн бус орлогоор хөгжлийн сан байгуулах, уг сангийн эх үүсвэр зориулалтыг тогтоох, сангийн хөрөнгийн зарцуулалтын журам, тайланг батлах”, 29 дүгээр зүйлийн 29.1.1-д “орон нутгийн төсвийн бус орлогоор хөгжлийн санг бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах” гэсэн заалтууд буюу Аймгийн хөгжлийн сан байгуулах хууль, эрхийн актын үндэслэлийг хүчингүй болгосон байна.

Үүнтэй холбогдуулан Сангийн сайдын 2016 оны 02-р сарын 16-ны өдрийн 4-3/760 дугаар албан бичгээр орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас байгуулсан орон нутгийн тусгай сангуудыг татан буулгах ажлыг зохион байгуулах, татан буугдсан сангуудаас хэрэгжүүлж байсан үйл ажиллагааг хэвээр үргэлжлүүлэх шаардлагатай бол Засаг дарга, эсвэл ЗДТГ-ын төсөвт тусгай хөтөлбөр, зориулалтаар орлого, зарлагыг тусган төлөвлөж, тайлагнах гэсэн зөвлөмжийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн боловч өнөөг хүртэл Аймаг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг үргэлжлүүлсээр байна.

Нэгэнт холбогдох хууль, эрх зүйн актыг зөрчин Аймаг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг явуулж ирсэн учир сангийн санхүүгийн тайлан гаргалгүй, төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон төлөвлөж, батлалгүйгээр өнөөдрийг хүрсэн байна.

Иймээс цаашид Аймаг хөгжүүлэх санг татан буулгаж, эх үүсвэрийг ОНХС-д төвлөрүүлэх эсэх, эсвэл Сангийн яамны өгсөн зөвлөмжийн дагуу аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын төсөвт тусгай хөтөлбөр, зориулалтаар орлого, зарлагыг тусган төлөвлөж, тайлагнах эсэхийг судалж, оновчтой шийдвэрлэх нь зүйтэй юм.

Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт оновчтой байна уу?

Сангийн хөрөнгийн 20,0 хүртэлх хувийг төсвийн цоорхойг нөхөх, урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болгон зарцуулж байна.

Аймаг хөгжүүлэх санд дараах эх үүсвэрүүдийг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- УИХ-ын гишүүдийн тойрогтоо зарцуулах санхүүжилтээс 4390,0 сая төгрөг / 2009 онд 1,500.0 сая төгрөг, 2010 онд 990.0 сая төгрөг, 2012 онд 1,900.0 сая төгрөг /
- Орон нутгийн төсвөөс 1,000.0 сая төгрөг / 2011 онд /
- Үйл ажиллагааны явцад хуримтлуулсан 15,6 сая төгрөгийн хүүгийн орлого зэрэг нийт **5405,6 сая төгрөг.**

2009 онд аймгийн ИТХТ-ээс баталсан журмаар 2009-2012 онуудад ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр хүүгүй, 3 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 276 иргэн, аж ахуйн нэгжид 5,287.6 сая төгрөгийн зээл олгосон бол 2013, 2016 онд орсон өөрчлөлтөөр уг зээлээс гадна сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг аймаг, сумын ойн арга хэмжээ, гадаад харилцаа, хамтын ажиллагааны ажил, үйлчилгээний зардал, аймгийн ИТХ, Засаг даргын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, тайлагнах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд зарцуулахаар зохицуулснаар уг сангийн үндсэн зорилгыг алдагдуулж, төсвийн цоорхойг нөхөх, урсгал зардлыг санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Ингэснээр тус сангаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд гадаад томилолт нэрээр 2015 онд 9,9 сая, 2016 онд 7,7 сая төгрөгийн аялал жуулчлалын зардал, 2016 онд аймаг байгуулагдсаны 85 жилийн ойн үндэсний их баяр наадмыг тэмдэглэх үйл ажиллагаанд 10,0 сая төгрөг, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэвлүүлэхэд 67,6 сая

төгрөгийн зэрэг нийт **95,2 сая** төгрөгийн үр ашиггүй, төлөвлөгдөж, батлагдаагүй урсгал зардлуудыг санхүүжүүлжээ.

Сангийн хөрөнгөнөөс 2009-2014 онуудад журамд заасан зориулалтаас гадуур нийт **726,1 сая** төгрөгийн өртөг бүхий дараах хөрөнгө оруулалт, урсгал зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- *Сүхбаатар, Мандал сумдад мал нядалгааны цех, мах хадгалах зоорь барих хөрөнгө оруулалтад 396,1 сая төгрөг / 2009 он /,*
- *Хэрх тосгонд хүлэмж барих хөрөнгө оруулалтад 30,0 сая төгрөг./ 2011 он /*
- *Хүн амын орлогын албан татварын буцаан олголтод 300,0 сая төгрөг /2014 он/*

Аймаг хөгжүүлэх сангийн журмын 3.4.1-д заасны дагуу сан хариуцсан ажилтны цалин хөлс болон бусад зардалд 45,5 сая төгрөгийг зарцуулсан байна.Үүнд:

- *Сан хариуцсан мэргэжилтний цалин, томилолт, холбоо, бичиг хэргийн зардалд 41,3 сая төгрөг / 2009-2016 он /*
- *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны болон ноториатын хөлсөнд 0,9 сая төгрөг /2014-2016 он /*
- *Принтер, сейф, ширээ, сандал зэрэг үндсэн хөрөнгө худалдан авахад 3,3 сая төгрөг / 2009-2016 он /.*

Дээр дурдсанчлан 2009-2016 оны хооронд тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдаагүй нийт **866,8 сая** төгрөгийн хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг Аймаг хөгжүүлэх сангаас санхүүжүүлснээс шалтгаалан тус сангийн эх үүсвэр энэ хэмжээгээр буурч 2016 оны 09 сарын 20-ны өдрийн байдлаар **4,538.8 сая** төгрөг болсон байна.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр олгосон зээлийн талаар

Анх Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан нэртэйгээр байгуулагдсан Аймаг хөгжүүлэх сангаас 2009-2012 онуудад жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 276 иргэн, аж ахуйн нэгжид 5,287.6 сая төгрөгийн зээлийг хүүгүй, 3 жилийн хугацаатай олгосон байна.

2009-2012 онд дараах иргэн аж ахуйн нэгжүүдэд ямар ч барьцаа хөрөнгөгүйгээр зээл олгосон байна. Үүнд:

2009 онд:

- *Улаанбаатар хотын харьяалалтай, Ж.Эрдэнэбаяр захиралтай “Нийслэл хүнс трейд” ХХК- д 300,0 сая төгрөг,*
- *Мандал суманд байршилтай, Ц.Төртогтох захиралтай “Бум-Эрдэнэ” ХХК-д 60,0 сая төгрөг,*
- *Сүхбаатар сумын П.Энхжаргал захиралтай “Төгс хөвгүүд” ХХК- ийн Их Монгол зоогийн газарт 50,0 сая төгрөг,*
- *Түшиг суманд байршилтай, С.Санжсүрэн захиралтай “Зэлтэр хүрхрээ” хоршоонд 30,0 сая төгрөг,*

- *Хэрх тосгоны харьяат иргэн Д.Сүхболдод 30,0 сая төгрөг,*
- *Сүхбаатар сумын харьяат иргэн Л.Хосбаярт 15,0 сая төгрөг,*
- *Шаамар сумын харьяат иргэн Ш.Эрдэнэчимэгт 10,0 сая төгрөг,*
- *Сүхбаатар сумын харьяат иргэн Ш.Энхтуяад 6,0 сая төгрөг,*
- *Сүхбаатар сумын харьяат иргэн Ч.Даваасүрэнд 3,0 сая төгрөг,*
- *Сүхбаатар сумын харьяат иргэн Д.Баяржаргалд 2,0 сая төгрөг,*

2010 онд :

- *Сүхбаатар сумын харьяат иргэн иргэн Д.Нямсүрэнд 20,0 сая төгрөг,*
- *Сайхан сумын харьяат иргэн Р.Шийлэгжамбалд 30,0 сая төгрөг,*

2011 онд:

- *Сүхбаатар сумын харьяат иргэн Ж.Наранчимэгт 50,0 сая төгрөг,*

2012 онд:

- *Ерөө сумын харьяат иргэн Л.Аззаяад 20,0 сая төгрөг,*
- *Сант сумын харьяат иргэн С.Эрдэнэбатад 18,0 сая төгрөг,*
- *Сүхбаатар сумын харьяат иргэн М.Болор-Эрдэнэд 10,0 сая төгрөг,*

Дараах 9 зээлдэгчид зээл олгохдоо итгэмжлэл хийлгээгүй бусдын эзэмшлийн хөрөнгийг барьцаанд авсан байна. Үүнд:

2010 онд

- *Иргэн Д.Ичинхорлоод 14,0 сая төгрөг,*

2011 онд

- *“Бага буурагчин” ХХК-д 50,0 сая төгрөг,*
- *Иргэн Б.Нарангэрэлд 10,0 сая төгрөг,*
- *Иргэн Т.Хүрэлхүүд 30,0 сая төгрөг,*

2012 онд

- *Иргэн Д.ХашбаатарТ 15,0 сая төгрөг,*
- *Иргэн С.Отгонбаярт 7,0 сая төгрөг,*
- *Иргэн М.Энхбаярт 8,0 сая төгрөг,*
- *Иргэн Б.Батзоригт 20,0 сая төгрөг,*
- *Иргэн Д.Эрдэнэбаярт 30,0 сая төгрөг,*

Зарим аж ахуйн нэгж, иргэний зээлийн барьцаа хөрөнгөд өмчлөх бус эзэмшиж, ашиглаж буй газрын гэрчилгээ, автомашины гэрчилгээ, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар зэргийг авсан бол зарим хөрөнгийн үнэлгээ нь өгсөн зээлийн хэмжээнд хүрэхгүй байх зэргээр тухайн үеийн сан хариуцсан мэргэжилтэн зэрэг албан тушаалтнуудын хувийн үзэмжээр барьцаа хөрөнгийг тогтоож байсан байна.

**Залуу гэр бүлд зориулсан орон сууц барих ажилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр
олгосон зээлийн талаар**

Аймгийн ИТХТ-ийн 2013 оны 26-р тогтоолоор батлагдсан журмын 3.2.1 болон 2014 оны 47-р тогтоолоор шинэчлэн баталсан журмын 3.2-дахь “Сангийн нийт хөрөнгийн 80 хувийг хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр, залуу гэр бүлд орон сууцны дэмжлэг үзүүлэх, залуу гэр бүлд зориулсан орон сууцанд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхэд зарцуулна” гэсэн заалтуудын дагуу 2014-2016 онд 5 аж ахуйн нэгжид нийт **2270,0 сая** төгрөгийн зээлийг тодорхой нөхцөлтэйгөөр олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 /сая төгрөгөөр /

№	Зээлдэгчийн нэрс	Зээлийн зориулалт	Зээл олгосон		Зээл төлөх		Хүүгийн хэмжээ /жилийн/
			огноо	дүн	огноо	дүн	
1	Видү ХХК	Сүхбаатар суманд 7 давхар орон сууц барих	25/12/2013	250,0	01/09/2015	262,6	3%
1	"Таванхан уул" ХХК	Сүхбаатар суманд баригдах 10 давхар орон сууц барих	9/17/2014	500.0	9/17/2015	500.0	/хүүгүй/
2	"Ганмон энжэлс" ХХК	Цагааннуур, Ерөө, Шаамар суманд тус бүр 25 айлын, Баянгол суманд 30 айлын орон сууц барих	9/17/2015	720.0	9/17/2016	720.0	/хүүгүй/
3	"Гурван тулгаат цамхаг" ХХК	Сүхбаатар сумын 8-р багийн нутаг дэвсгэр дээр 10 айлын таун хаус барих	10/20/2015	500.0	10/20/2016	500.0	/хүүгүй/
4	"Алтанбилэг" ХХК	Алтанбулаг сумын "Хаус хороолол" хотхонд 10 айлын орон сууц барих	4/15/2016	300.0	4/15/2017	300.0	/хүүгүй/
Нийт дүн				2,270.0		2,270.0	

Дээрх компаниудад зээл олгохдоо барьцаа хөрөнгийг хэрхэн үнэлж авсныг тус сангийн мэргэжилтэн З.Загдсүрэнгээс тодруулахад “Голомт банкны эдийн засагчаас банкны шалгуур үзүүлэлтийг авч аймгийн төвийн барилгын 1м2-ыг 1,1 сая төгрөгөөр үнэлж, түүний 70 хувиар тооцон, УБ хот болон бусад үйлдвэрлэл, үйлчилгээний барилгыг банктай адил ханшаар үнэлэн барьцаанд авсан” гэсэн тайлбарыг өгсөн болно.

Харин 2013 онд “Видү” компанид олгосон 250,0 сая төгрөгийн зээлэнд 56,6 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгө барьцаалсан байна.

Дээрх байдлуудаас харахад Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан болон Аймаг хөгжүүлэх сангийн журамд зээлийн барьцаа хөрөнгийн төрөл, үнэлгээний талаар тодорхой зааж өгөөгүйгээс сан хариуцсан мэргэжилтнүүд өөр өөрийн арга,

үнэлэмжээр барьцаа хөрөнгийг үнэлж, зарим зээлийг огт барьцаагүйгээр олгож байсан нь зээл эргэн төлөгдөхгүй, хугацаа хэтрэх үндсэн нөхцөл болсон байна.

Бүлэг 2

Аймаг хөгжүүлэх сангаас олгож буй зээлийг үр ашигтай зарцуулж байна уу?

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр олгосон зээлийн 58,5 хувийг зориулалт бусаар зарцуулсан бөгөөд нийт олгосон зээлийн 54,1 хувь нь хугацаа хэтэрснээс сангийн эх үүсвэрийн 90,2 хувь нь хугацаа хэтэрсэн авлага хэлбэрт шилжсэн байна.

2.1. Олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж байна уу?

Орон сууцны хөрөнгө оруулалтын чиглэлээр олгосон зээл зориулалтын дагуу зарцуулагдсан бол жижиг дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр олгосон зээлийн 58,5 хувь нь зориулалт бусаар зарцуулагдсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр 2009-2012 онд иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн зарцуулалт

Аймгийн Аудитын газраас 2013 оны 11-р сард хийгдсэн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар тус сангаас жижиг дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр 2009-2012 онд олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтад холбогдох судалгаа хийсний үндсэн дээр 2009 онд олгосон зээлийн 58,8 хувь буюу 574,0 сая төгрөгийг, 2010 онд 57,3 хувь буюу 449,0 сая төгрөгийг, 2011 онд 48,6 хувь буюу 611,1 сая төгрөгийг, 2012 онд 64,2 хувь буюу 1458,8 сая төгрөгийг гэх мэтчилэн нийт олгосон зээлийн **58,5 хувь болох 3,092.9 сая төгрөгийг** зориулалтаар нь ашиглаагүй байна гэсэн дүгнэлт өгсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 2

Зээл олгосон он		Нийт төсөл, зээл	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй
2009	тоо	32	15	17
	сая.төг	975,5	401,5	574,0
2010	тоо	43	23	20
	сая.төг	783,0	334,0	449,0
2011	тоо	75	39	36
	сая.төг	1257,0	645,9	611,1
2012	тоо	126	43	83
	сая.төг	2272,1	813,3	1458,8
НИЙТ	тоо	276	120	156
	сая.төг	5287,6	2194,7	3092,9

Хэрэгжилтийн	тоо	43,5	56,5
хувь	Зээлийн дүнгээр /сая.төг/	41,5	58,5

2009 онд олгосон “Шим” компанийн сүү боловсруулах 50,0 сая төгрөгийн, “Төгс хөвгүүд” ХХК-ийн Их Монгол зоогийн газрын халуун тогооны хоолны 50,0 сая төгрөгийн, “Бум-Эрдэнэ” ХХК-ийн усалгаатай газар тариалан эрхлэх 60,0 сая төгрөгийн, Уранчимэг эзэнтэй ТАУС ББН-ийн шингэрүүлсэн шатдаг хий үйлдвэрлэх 25,0 сая төгрөгийн, ЭМ-БИ-БИ-СИ компанийн үнээний ферм байгуулах 40,0 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2010 онд олгосон “Шинэ бадрах” ХХК-ийн өнгөт хавтан, паркетан шалны үйлдвэрийн 30, 0 сая төгрөгийн, Тултын тохой” ХХК-ийн хорголжин тэжээлийн үйлдвэр байгуулах 30,0 сая төгрөгийн, “Силкроуд межик” ХХК-ийн бяслагны үйлдвэр байгуулах 50,0 сая төгрөгийн, “Агро жавхлан” ХХК-ийн тоосгоны үйлдвэр байгуулах 30,0 сая төгрөгийн, “Баян-Ундарга” ХХК-ийн хорголжин тэжээлийн үйлдвэр байгуулах 50,0 сая төгрөгийн, “Чагтай” ХХК-ийн гурилын үйлдвэр байгуулах 50,0 сая төгрөгийн, Орхоны эрэг ХХК-ийн сүү боловсруулах үйлдвэр байгуулах 36,0 сая төгрөгийн зээлийн эх үүсвэрийг төслийн дагуу зарцуулаагүй байна.

2011 онд олгосон “Үжээд” ХХК-ийн цайны үйлдвэр байгуулах 10,4 сая , “Бага буурагчин” ХХК хуурай өндөг үйлдвэрлэх 40,0 сая, “Зүүвч ивэн бургалтай” ХХК гурилын үйлдвэр байгуулах 25,0 сая, “Үүр хайрхан” хоршоо сүү боловсруулах цехийн зориулалтаар 10,0 сая, “Эрчин” ХХК төмөр хийцийн үйлдвэр байгуулах 12,0 сая төгрөгийг,

2012 онд “Сэлэнгэ Жидү” ХХК тэжээлийн үйлдвэр байгуулах 40,0 сая, “Ойн Эхлэл” ХХК хайрга боловсруулах үйлдвэр байгуулахаар 25,0 сая төгрөгийн зээл авсан боловч тус тус зориулалт бусаар зарцуулж зээлийн гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.

Иргэдийн хувьд 2009 онд Сүхбаатар сумын иргэн Ш.Энхтуяагийн хүнсний ногоо тариалах 6,0 сая, Ж.Тунгалагийн жимс, жимсгэнэ тариалах 11,0 сая, Н.Эрдэнэчимэгийн цаасан уутны үйлдвэр байгуулах 47,0 сая төгрөгийн, Д.Цогтжаргалын цэцгийн хүлэмж байгуулах 10,0 сая төгрөгийн, Д.Ичинхорлоогийн хүүхдийн тоглоомын газар байгуулах 14,0 сая төгрөгийн, Д.Нямсүрэнгийн чипс, попкорны үйлдвэр байгуулах 20,0 сая төгрөгийн, Ч.Диваанансалын гурилын үйлдвэр байгуулах 25,0 сая төгрөгийн, Шаамар сумын иргэн Ш.Эрдэнэчимэгийн блокны үйлдвэр байгуулах 10,0 сая, Мандал сумын иргэн Д.Цэнд-Аюушийн молтогчин туулай үржүүлгийн газар байгуулах 7,0 сая, 2010 онд Сүхбаатар сумын иргэн Л.Довчинбазарын хоолны газар байгуулах 13,0 сая төгрөгийн, Сайхан сумын иргэн Р.Шийлэгжамбалын хими цэвэрлэгээ байгуулах 30,0 сая төгрөгийн зэрэг төслүүд огт хэрэгжээгүй байна.

2011 онд Сайхан сумын иргэн Ж.Даваахүрэл тэжээлийн 35,0 сая, Мандал сумын иргэн А.Цэрэндондов хадаасны үйлдвэр 20,0 сая, Сүхбаатар сумын иргэн Д.Мөнхгэрэл нойтон салфетка үйлдвэрлэх 50,0 сая, П.Баасандорж пиццаны 24,0 сая,

Д.Энхтулга сүү үйлдвэрийн тоног төхөөрөмж 30,0 сая, Улаанбаатар хотын иргэн Г.Хүрэлхүү хаягдал дугуй боловсруулах 30,0 сая, Н.Мөнхбат сүү цагаан идээ боловсруулах 10,0 сая, Цагааннуур сумын иргэн Д.Эрдэнэ-Оргил авто засварын газар 40,0 сая, Алтанбулаг сумын иргэн М.Наранцэцэг, Б.Ганчимэг нар оймсны үйлдвэр тус бүр 20,0 сая, Орхонтуул сумын иргэн Ж.Бакатжан багсармал тэжээлийн үйлдвэр 20,0 сая, Ерөө сумын иргэн Л.Норжмаа КАТВ-ийн телевиз 39,0 сая төгрөгийн,

2012 онд Сүхбаатар сумын иргэн Б.Батмөнх өнгөлгөөний тоосгоны үйлдвэр 40,0 сая, Б.Дөлгөөн шахмал түлшний үйлдвэр 30,0 сая, Б.Цагаанхүү хуванцар сав үйлдвэрлэх 30,0 сая, Б.Сэргэлэнбаатар пено блокны үйлдвэр 35,0 сая, Г.Бадамсэрээжид вакуум цонхны үйлдвэр 30,0 сая, С.Бааст хаягдал гялгар уут, полиэтилен дахин ашиглах үйлдвэр байгуулахаар 20,0 сая төгрөгийн зээл авсан боловч эдгээр төслүүд огт хэрэгжээгүй байна. / **томоохон зээлдэгч нарыг дурдлаа** /

Төрийн албаны тухай хуулиар аж ахуйн ажил давхар эрхлэхийг хориглосон байхад төрийн жинхэнэ албан хаагч болох аймгийн ХХААЖДҮГ-ын мэргэжилтэн Ж.Хүдэрбаатарт талхан цех барих, МХГ-ын СНХХХ-ийн дарга Б.Дарихжавт спортын хувцасны үйлдвэр байгуулах төсөлд тус бүр 15,0 сая төгрөгийн зээл олгосон боловч төрийн жинхэнэ албан хаагч эдгээр хүмүүсийн төсөл цаасан дээрх тоо чигээрээ үлдэж Ж.Хүдэрбаатарын зээл өнөөг хүртэл нэг ч төгрөгийн төлөлт хийгдээгүй байгаа бол Б.Дарихжавт олгосон зээл 9,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Дээрх жишээнүүдээс харахад зээл олгосон төслүүдийг хэрэгжүүлж, зээлийг зориулалтын дагуу зарцуулсан бол Сэлэнгэ аймаг өнөөдөр үйлдвэрлэл, үйлчилгээний бүх салбар иж бүрэн хөгжсөн, энэ хэрээр зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэж, дараагийн төслүүдийг дахин санхүүжүүлж, үр дүнд хүрсэн байх дүр зураг харагдаж байгаа боловч төсөл хөтөлбөрийн бодит байдал, тооцоо судалгааг нягталж санхүүжүүлээгүйгээс ихэнх нь огт хэрэгжээгүй байна.

Залуу гэр бүлд зориулсан орон сууцанд дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон зээлийн зарцуулалт

Залуу гэр бүлийг хөнгөлөлттэй үнээр орон сууцжуулах зорилгын хүрээнд “Аймаг хөгжүүлэх сан” -гаас 2013-2016 онд 5 аж ахуйн нэгжид **2,270.0 сая** төгрөгийн зээл олгосон байна.

Гүйцэтгэлийн аудитын явцад зээлийн ашиглалт, зарцуулалтын байдлыг газар дээр нь очиж үзэхэд дараах байдалтай байлаа. Үүнд:

- 2013 онд 250,0 сая төгрөгийн зээл авсан “Видү” ХХК нь Сүхбаатар суманд 7-н давхар 112 айлын орон сууцыг барьж 2014 онд бүрэн ашиглалтад оруулсан, /1м²-ыг 1,25 сая төгрөгөөр буюу м²-аас шалтгаалан 36,6-82,5 сая төгрөгөөр борлогдсон /
- 2014 онд 500,0 сая төгрөгийн зээл авсан “Таванхан уул” ХХК нь дээрх “Видү” ХХК-тай хамтран Сүхбаатар суманд 54 айлын 10 давхар, бүрэн цутгамал, төмөр бетонон карказтай, 180-200 хүүхдийн цэцэрлэгтэй орчин үеийн загвар бүхий барилгыг 2015 онд барьж ашиглалтад оруулсан байна. /1м²-ыг

1,5 сая төгрөгөөр буюу м²-аас шалтгаалан 63,4-120,0 сая төгрөгөөр борлуулж байгаа, одоо 21 байр борлогдоогүй байна. /



/ Сүхбаатар суманд баригдсан 7 болон 10 давхар айлын орон сууц /

- 2015 онд 720,0 сая төгрөгийн зээл авсан “Ганмон энжелс” ХХК нь Цагааннуур суманд баригдсан 25 айлын орон сууцыг улсын комисст хүлээлгэн өгч бүрэн ашиглалтад оруулан, Баянгол суманд баригдсан 30 айлын орон сууцыг улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болсон бол Шаамар, Ерөө сумын тус бүр 25 айлын орон сууцны барилга нь 85,0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлбарлаж байна.

/ 1 м²-ыг 1,1 сая төгрөгөөр буюу м²-аас шалтгаалан 1 айлын орон сууц нь 34,0-54,0 сая төгрөгөөр борлуулахаар төлөвлөж байгаа /



/ Шаамар сумын 25 айлын орон сууц/



/Ерөө сумын 25 айлын орон сууц/

- 2015 онд 500,0 сая төгрөгийн зээл авсан “Гурван тулгат цамхаг” ХХК нь Сүхбаатар суманд 10 айлын таун хаус барихаар зээл авсан боловч 6 айлын таун хаусыг барьсан бөгөөд ажлын гүйцэтгэл 80,0 хувьтай гэж тайлбарлаж байна. / 1 м²-ыг 0,8-0,9 сая төгрөгөөр буюу м²-аас шалтгаалан 1 айлын таун хаусыг 53,3-79,9 сая төгрөгөөр борлуулахаар төлөвлөж байгаа /



/ 2 айлын орон сууц /



/ 4 айлын орон сууц /

- 2016 онд “Алтанбилэг” ХХК нь Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт 10 айлын орон сууц бүхий “Хаус хороолол” барихаар 300,0 сая төгрөгийн зээл авч, зоорийн давхар бүхий 12 айлын 3 давхар орон сууц барьж эхэлсэн байна. Одоогоор зоорийн давхар болон 1,2 давхарын өрлөгийг бүрэн хийж дуусгасан ба 2017 онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байна. /1м²-ыг 0,65 сая төгрөгөөр буюу 1 айлын орон сууцыг 59,8 сая төгрөгөөр борлуулахаар төлөвлөж байгаа /



/ Алтанбулаг суманд баригдаж буй 12 айлын орон сууц /

Залуу гэр бүлд зориулсан орон сууц барихаар гэрээ байгуулж, “Аймаг хөгжүүлэх сан”-гаас дэмжлэг авсан аж ахуйн нэгжүүд зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч “Ганмон энжелс”, “Гурван тулгат цамхаг” компаниудын барилгын ажил бүрэн ашиглалтад ороогүй байна.

2.2. Зээлийн эргэн төлөлт гэрээт хугацаандаа хийгдэж байгаа эсэх?

Нийт олгосон зээлийн 54,1 хувьтай тэнцэх 4,092.3 сая төгрөгийн зээл гэрээт хугацаандаа төлөгдөөгүй байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр 2009-2012 онд олгосон зээлийн эргэн төлөлт

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас зээл авсан зээлдэгчид нь аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргатай байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу 3 жилийн хугацаанд зээлийг төлж барагдуулахаар үүрэг хүлээсэн байна.

Тус сангаас 2009-2012 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр олгосон зээлийн эргэн төлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3

№	Зээл олгосон он	олгосон зээл		төлсөн зээл		үлдэгдэл зээл	
		зээлдэгчийн тоо	дүн	зээлдэгчийн тоо	дүн	зээлдэгчийн тоо	дүн
1	2009 он	32	975.5	15	524.2	17	451.3

2	2010 он	43	783.0	29	561.3	14	221.7
3	2011 он	75	1,257.0	43	796.1	32	460.9
4	2012 он	126	2,272.1	48	1283.7	78	988.4
	Нийт дүн	276	5,287.6	135	3165.3	141	2122.3

2009-2012 онд 276 төсөлд олгосон 5,287.6 сая төгрөгийн зээл өнөөгийн байдлаар бүрэн төлөгдөж дууссан байх атал 135 зээлдэгчид олгосон 3,165.3 сая төгрөгийн зээл төлөгдөж, 141 зээлдэгчийн 2,122.3 сая төгрөг буюу олгосон зээлийн 40,1 хувь нь төлөгдөлгүйгээр хугацаа хэтэрсэн байна. /Хавсралт 1-д дэлгэрэнгүй харуулав/

Аудитын явцад судалгаа хийж үзэхэд зээл олгосноос хойш 4-7 жил өнгөрсөн атал:

➤ **42 зээлдэгчид олгосон 751,7 сая төгрөгийн зээл** /Хавсралт 2-т дэлгэрэнгүй харуулав/ **өнөөг хүртэл нэг төгрөгийн ч төлөлт хийгдээгүй** байна. Үүнд:

- 2009 онд зээл авсан “Төгс хөвгүүд” ХХК 50,0 сая, “Зэлтэр хүрхрээ” хоршоо 30,0 сая, иргэн Ш.Эрдэнэчимэг 10,0 сая, Д.Цэнд-Аюуш 7,0 сая, Мандал сумын иргэн Г.Жаргалтуяа өөрийн болон “Арвин ургац цэцэглэнэ” хоршооны нэрээр нийт 8,0 сая төгрөгийн,
- 2010 онд зээл авсан “Чагтай” ХХК 50,0 сая, иргэн Ч.Диваанансал 25,0 сая, Д.Нямсүрэн 20,0 сая, Ж.Хүдэрбаатар 15,0 сая, Д.Ичинхорлоо 14,0 сая, Ж.Зояа, Д.Энхцэцэг нар тус бүр 10,0 сая төгрөгийн,
- 2011 онд зээл авсан “Зүүвч Ивэн бургалтай” ХХК 25,0 сая, “Мон-Апи” ХХК 15,0 сая, иргэн Ж.Наранчимэг 50,0 сая, Б.Ганчимэг 20,0 сая, Д.Оюунгэрэл 15,0 сая, Д.Наранчимэг 9,4 сая төгрөгийн,
- 2012 онд зээл авсан “Шилмэл эсгий” ХХК 40,0 сая, “БМОНС” ХХК 15,0 сая, иргэн С.Дамба 35,0 сая, Ж.Эрдэнэцогт 31,8 сая, Л.Аззаяа 25,0 сая, Т.Өлзий-Орших 20,0 сая, С.Ганзориг 18,0 сая, Д.Сумъяа, Б.Идэрцог, Д.Хашбаатар нар тус бүр 15,0 сая, А.Баярмаа 12,0 сая, М.Болор-Эрдэнэ, Д.Цэндсүрэн нар тус бүр 10,0 сая төгрөгийн.

➤ **Эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн, 10,0 сая төгрөгөөс дээш үлдэгдэлтэй 48 зээлдэгчид ногдох 1,104.8 сая төгрөгийн зээлийн** /Хавсралт 3-д дэлгэрэнгүй харуулав / **томоохноос нь дурдвал:**

- 2009 онд олгосон “Нийслэл хүнс трейд” компани 179,8 сая, “Шим” компани 40,0 сая, “Бум-Эрдэнэ” ХХК 34,0 сая, иргэн Б.Баттогтох 37,5 сая, Б.Мөнх-Эрдэнэ 18,5 сая, Д.Сүхболд 12,5 сая төгрөгийн,
- 2010 онд олгосон “Тултын тохой” ХХК 17,0 сая, иргэн Р.Шийлэгжамбал 19,6 сая, Н.Эрдэнэчимэг 23,0 сая төгрөгийн,
- 2011 онд олгосон “Бага буурагчин” ХХК 40,0 сая, “Орхон импекс” ХХК 37,0 сая, иргэн С.Арсланбаяр 29,4 сая, С.Соёлбаатар 25,0 сая, Т.Хүрэлхүү 24,0 сая, Д.Энхтулга 17,0 сая, Ц.Тогтох 16,5 сая, Д.Эрхэмбаяр 15,0 сая төгрөгийн,

- 2012 онд олгосон “Сэлэнгэ буудай” ХХК 20,0 сая, “Даваат хүдэр” ХХК 20,0 сая, “Их дүмбэрэл” ХХК 13,0 сая, иргэн М.Баярмаа 49,2 сая, Ш.Алтантулга 36,5 сая, К.Тлеухан 32,0 сая, Б.Буянхишиг 28,0 сая, С.Бааст, Ш.Отгонтуяа, Б.Цагаанхүү нар тус бүр 17,0 сая, З.Баярсүрэн 16,0 сая, М.Батзориг 15,1 сая, Б.Дөлгөөн, Г.Бадамсэрээжид нар тус бүр 15,0 сая төгрөгийн.

Эдгээрээс аймгийн төр, захиргааны удирдах байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчидтай хамаарал бүхий 13 этгээдийн авсан 171,2 сая төгрөгийн зээлийг 1 жилийн хугацаанд төлж барагдуулах нэмэлт гэрээг 2015 оны 11-р сарын 26-ны өдөр сан хариуцсан мэргэжилтэн З.Загдсүрэн холбогдох албан хаагчидтай байгуулсан боловч гэрээт хугацаанд дөнгөж 14,1 хувь болох 24,3 сая төгрөгийг л төлж барагдуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4 /сая төгрөгөөр /

№	Зээлдэгчийн нэр	Нэмэлт гэрээ байгуулсан		анх олгосон зээлийн хэмжээ	2015 оны үлдэгдэл зээл	2016 онд төлсөн	2016-12-10-ны өдрийн үлдэгдэл
		албан хаагчдын нэр	албан тушаал				
1	Б.Сэргэлэнбаатар	Ш.Энхмаа	ТЗУХ-ийн мэргэжилтэн	35,0	12,0	0,7	11,3
2	С.Ганзориг	П.Баярцэцэг	аймгийн ИТХ-ын ахлах мэргэжилтэн	18,0	10,5	4,3	6,2
3	Б.Идэрцог	Ч.Дэлгэрмөрөн	бичиг хэргийн ажилтан	15,0	15,0	-	15,0
4	Б.Дөлгөөн	Б.Бүрэнжаргал	ХБХ-ийн мэргэжилтэн	30,0	15,0	-	15,0
5	С.Бааст	Б.Болорзул	ТЗУХ-ийн дарга	20,0	17,0	-	17,0
6	А.Эрдэнэцэцэг	А.Эрдэнэгэрэл	ХБХ-ийн мэргэжилтэн	15,0	7,0	6,7	0,3
7	Ц.Цогтжаргал	А.Эрдэнэгэрэл	ХБХ-ийн мэргэжилтэн	10,0	10,0	5,3	4,7
8	М.Мөнх-Эрдэнэ	Д.Нансалмаа	НБХ-ийн мэргэжилтэн	20,0	9,5	1,0	8,5
9	С.Дамба	Д.Лувсандагва	Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга	35,0	35,0	-	35,0
10	Б.Баттогтох	Д.Ган-Отгон	хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	15,0	14,5	0,5	14,0
11	Э.Оюунсайхан	Э.Оюунболд	аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга	5,0	5,0	4,7	0,3
12	Э.Мягмар	Б.Эрдэнэцэцэг	үйлчлэгч	6,3	3,7	-	3,7
13	Ц.Тогтох	Ц.Отгонтуяа	НБХ-ийн мэргэжилтэн	22,0	17,0	1,1	15,9
Нийт дүн				246,3	171,2	24,3	146,9

Дээрх хүмүүсээс гадна аймгийн ИТХ-ын төлөөлөгч, хэлтэс, агентлагийн дарга, бусад төр, захиргааны байгууллагад ажиллаж байсан, одоо ажиллаж буй албан

хаагчдын өөрийн болон хамаарал бүхий этгээдүүдийн нэрээр авсан их хэмжээний зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байгаа тул холбогдох арга хэмжээ авч, санг хохиролгүй болгох нь зүйтэй юм.

Аудитын явцад зээлийн эргэн төлөлт, үлдэгдлийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- *Зээлийн эргэн төлөлтийг буруу тооцоолсноос 2013 онд “Орхоны эрэг” ХХК-ийн 5,0 сая төгрөгийн, 2015 онд иргэн А.Цэрэндолгорын 0,3 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг хааж, барьцаа хөрөнгийг олгосон байна.*
- *Иргэн Д.Энхтулгын 2013 оны 12-р сарын 31-нд төлсөн зээлийн эргэн төлөлт 4,0 сая төгрөгийг хасалт хийлгүйгээр үлдэгдлийг буруу тайлагнасан байна.*

Залуу гэр бүлд зориулсан орон сууцыг дэмжих чиглэлээр олгогдсон

зээлийн эргэн төлөлт

Аймаг хөгжүүлэх сангаас 2013-2015 онд 5 компанид олгосон 2,270,0 сая төгрөгийн зээлээс 4 компанийн 1,970.0 сая төгрөгийн зээлийн эргэн төлөгдөх хугацаа дууссан байхад нэг ч төгрөгийн төлөлт хийгдээгүй байна. Үүнд:

- *2013 оны 12-р сард “Видү” ХХК-д 250,0 сая төгрөгийн зээлийг 3 сарын хугацаатай олгосон боловч тус компанийн хүсэлтийн дагуу 2 удаа сунгагдсан хугацаа нь 2015 оны 9-р сарын 1-нд дууссан,*
- *2014 онд “Таванхан уул” ХХК-д олгосон 500,0 сая төгрөгийн зээлийн хугацаа 2015 оны 9-р сарын 30-нд дууссан,*
- *2015 онд “Ганмон энжелс” ХХК-д олгосон 720,0 сая төгрөгийн зээлийн хугацаа 2016 оны 9-р сарын 17-нд дууссан,*
- *2015 онд “Гурван тулгат цамхаг” ХХК-д олгосон 500,0 сая төгрөгийн зээлийн хугацаа 2016 оны 10-р сарын 17-нд дууссан,*

Аудитын явцад Видү, Таванхан-Уул компанийн удирдлагуудтай ярилцлага хийхэд дараах тайлбаруудыг өгч байна.

- *“Видү” ХХК-ны захирал Ц.Болд “Манай компани 2013 онд 7-н давхар 112 айлын орон сууцыг барьж дуусгахын тулд аймгийн Засаг даргаас дэмжлэг хүсч 250,0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийг авсан. Тухайн онд орон сууцны зээл арилжааны банкуудаар идэвхитэй олгогдож, борлуулалт сайн байсан. Үүнд урамшиж үйлчилгээний барилга бүхий 54 айлын 10 давхар орон сууцыг 2014 онд эхлүүлж, 7 эхний барилгын борлуулалтаас орж ирсэн хөрөнгөө тус барилгад зарцуулсан. Гэвч эдийн засгийн хямрал газар авч, ипотекийн зээл зогссон, өнөөдрийн байдлаар 21 айлын орон сууц борлогдоогүй байна. Нөхцөл байдал сайжирч байрны борлуулалт эхлэнгүүт зээлээ бүрэн төлөх болно”*
- *“Таванхан уул” ХХК-ны захирал Ц.Энхтөр “Манай компани 2014 онд 54 айлын 10-н давхар бүрэн цутгамал, төмөр бетонон карказтай, 180-200 хүүхдийн цэцэрлэгтэй орчин үеийн загвар бүхий барилга барьсан билээ. “Видү” ХХК-тай хамтран ажилладаг бөгөөд “Видү” ХХК бол захиалагч, хөрөнгө оруулагч компани, манайх гүйцэтгэгч компани гэхдээ энэ барилгад хамтран хөрөнгө*

оруулсан юм. Энэ барилгыг барихад 4,300.0 сая төгрөгийн эх үүсвэр шаардагдсан бөгөөд 2,200.0 сая төгрөгийн эх үүсвэр дутагдаж, 1,500.0 сая төгрөгийг Голомт банкны зээлээр, 500,0 сая төгрөгийг Аймаг хөгжүүлэх сангаас зээл авч хөрөнгө оруулалт хийсэн. Барилга ашиглалтанд орох явцад эдийн засгийн хямрал болж, байрны борлуулалт зогссон. Бид гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээр аймагт удаа дараа хямд үнээр байр өгөх саналыг гаргасан боловч аймгийн Засаг дарга С.Бүрэнбат “Бид өгсөн санхүүжилтээ л буцааж авах үүрэгтэй, байр авах боломжгүй, гэрээнд заасны дагуу зөвхөн залуу гэр бүлд санал болгох боломжтой юм” гэсэн хариу өгсөн. Бид боломжтой бүх арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд хүүхдийн цэцэрлэгийн тохижилтын ажлыг 12-р сард багтаан дуусгахаар ажиллаж байна. Тус сангаас авсан зээлээ боломж гарах тохиолдолд бүрэн төлөх болно”.

Аудитын явцаас харахад хоорондоо хамаарал бүхий Видү, Таванхан-Уул компаниуд нь 2013-2014 онуудад 2 удаагийн үйлдлээр нийт 750,0 сая төгрөгийн зээл авч 166 айлын орон сууц барьж ашиглалтад оруулснаас 145 айлын орон сууцыг буюу нийт орон сууцны 87,3 хувийг борлуулж, ойролцоогоор 8,200 сая төгрөгийн буюу авсан зээлээс **11 дахин** их орлого олсон бөгөөд төлөлтийг 2 удаа сунгасан хугацаа 2015 оны 9 сард дууссан байхад нэг ч төгрөгийн төлөлт хийгдээгүй байгаа нь зээлдэгчийн зүгээс төлүүлэх арга хэмжээ хангалтгүй, компанийн зүгээс зээл төлөх санаачлага гаргаагүйгээс шалтгаалсан гэж үзэж байна.

Зээлийн эргэн төлөлт хийгдээгүй шалтгаан болон зээлдэгч, зээлдүүлэгчийн зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дурдвал:

- “Видү” ХХК, “Таванхан уул” ХХК-иудын зээлийн гэрээг 2 удаа сунгасан хугацаа 2015 оны 9-р сард дууссан тул 2015 оны 12-р сард 13 ширхэг орон сууцыг зах зээлийн үнээс хямдаар буюу 10 давхар байрны 1 м²-г 1,35 сая, 7 давхар байрны 1м²-г 1,25 сая төгрөгөөр сангийн хяналтан дор борлуулж, 2016 оны 05-р сарын 1-ны өдрөөс 2016 оны 12-р сарын 15-ны өдрийг хүртэл сар бүр 95,6 сая төгрөг, нийт 765,0 сая төгрөгийн төлбөрийг төлөхөөр аймгийн Засаг даргатай тохиролцсон боловч байр борлогдохгүй байна гэсэн шалтгаанаар төлөлт огт хийгдээгүй байна.
- “Ганмон энжелс” ХХК-ний зээлийн гэрээний хугацаа 2016 оны 9-р сард дууссан боловч ипотекийн зээл зогссон, иргэдийн худалдан авах чадвар буурсан зэрэг шалтгааны улмаас зээлийн эргэн төлөгдөх хугацааг 2017 оны 7-р сар хүртэл сунгаж өгнө үү гэсэн хүсэлтийг аймгийн Засаг дарга Ш.Оргилд гаргасан байна.
- “Гурван тулгат цамхаг” ХХК-ийн зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн тул аймгийн Засаг даргын албан мэдэгдлийг 2016 оны 11-р сарын 3-нд хүргүүлсэн байна.

Хэдийгээр дээрх 4 компани зээлийг зориулалтын дагуу ашиглаж, орон сууц барьсан боловч зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрч, сангийн хөрөнгө нөхөн бүрдэхгүй байгаа тул алданги тооцох, зээлийн барьцаанд тавьсан хөрөнгүүдийг худалдан борлуулах зэргээр хамтран ажиллаж, санг хохиролгүй болгох нь зүйтэй юм.

Ялангуяа ашиглалтад оруулсан орон сууцныхаа 87,3 хувийг борлуулснаас авсан зээлээс 11,0 дахин их борлуулалтын орлого төвлөрүүлсэн, зээл барагдуулах бүрэн боломжтой Видү, Таванхан-Уул компаниудын авсан зээлийг гэрээний дагуу хүү, алданги тооцож нэн даруй төлүүлэх шаардлагатай байна.

2.3 Аймаг хөгжүүлэх сангийн үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөгдөж, дотоод хяналт хийгдэж байна уу?

Аймгийн Засаг даргын зүгээс хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч байгаа боловч сангийн хөрөнгийн нөхөн бүрдүүлэлтэд нөлөөлөхүйц үр дүнд хүрэхгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 47-р тогтоолоор баталсан Аймаг хөгжүүлэх сангийн журмын 5.1-д “Сангийн удирдлага нь аймгийн Засаг даргын зөвлөл байна” гэж заасан бөгөөд аймгийн Засаг даргын зөвлөл нь тус сангаас олгож буй зээлийн зориулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, гэрээний биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй билээ.

Үүний дагуу аймгийн Засаг дарга, сан хариуцсан мэргэжилтний зүгээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулахын тулд 2013 онд 10, 2014 онд 20, 2015 онд 37, 2016 онд 13 зэрэг нийт 80 зээлдэгчид хамаарах 1,577,3 сая төгрөгийн зээлийг шүүхэд шилжүүлснээр 12 зээлдэгчийн 165,3 сая төгрөгийн зээл хаагдаж, 23 зээлдэгчийн 197,8 сая төгрөгийн зээл төлөгдсөн байна.*
- *77 зээлдэгчид Засаг даргын албан мэдэгдлийг өгснөөр 14 зээлдэгчийн 111,8 сая төгрөгийн зээл хаагдаж, 14 зээлдэгчтэй дахин гэрээ байгуулж, 13 зээлдэгчийн гэрээний үүргийн биелэлт хангалтгүй боловч тодорхой хэмжээгээр төлж барагдуулснаар 96,3 сая төгрөгийн зээлийг төлүүлсэн боловч төлөөгүй 36 зээлдэгчийг шүүхэд шилжүүлээгүй байна.*
- *Шүүхийн захирамж гарсан боловч тогтсон хугацаандаа төлөлт хийхгүй байгаа 29 зээлдэгчийг ШШГА-д шилжүүлсэн байна.*
- *Хаяг, байршил нь тодорхойгүй Хушаат сумын иргэн Ж.Зояа, Д.Энхцэцэг, Ерөө сумын иргэн Л.Аззаяа, Сүхбаатар сумын иргэн Б.Ганчимэг, Т.Өлзий-Орших, С.Отгонбаяр нарын хаягийг тогтоолгохоор аймгийн Тахарын албанд хандан, Л.Аззаяа, С.Отгонбаяр нарын хаягийг тогтоолгож, шүүхэд шилжүүлсэн байна.*
- *2015-2016 онд барилгын компаниудад зээл олгохдоо ажлын хэсэг томилж, компаниудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна.*

Хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулахын тулд дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч 14 зээлдэгчийн 146,9 сая төгрөгийн зээлд нэмэлт гэрээ байгуулж, бусад 36 зээлдэгчийн 686,3 сая төгрөг / Хавсралт 4-т дэлгэрэнгүй харуулав / буюу нийт 833,2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн материалыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэлгүй, мэдэгдэл өгснөөр хязгаарласан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн дагуу дэргэдээ төсөв, санхүү, хөрөнгө, мөнгөний зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий Санхүүгийн хяналт, аудитын албыг ажиллуулж байгаа боловч зарцуулалт, бүрдүүлэлтийн их хэмжээний эрсдэл үүссэн Аймаг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд уг албаны зүгээс нэг ч удаа хяналт, шалгалт хийж, дүгнэлт өгөөгүй байна.

Аймаг хөгжүүлэх сангийн журмын 6.1-д “Аймгийн Засаг дарга сангийн тайланг жил бүр гаргаж, аймгийн ИТХ-д танилцуулна” гэж заасны дагуу сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн эргэн төлөлтийн 2013, 2015 оны тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулсан байна.

Сангийн журмын 5.3.2, 5.3.5-дахь заалтын дагуу Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал нь хөрөнгийн зориулалт, зарцуулалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих, сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дүн, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй билээ.

Энэ талаар аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга Э. Оюунболдоос тодруулахад “Тус сангаас зээл олгох үед Засаг даргын зөвлөлийн хуралд оролцдог бөгөөд тусгайлан комисс гаргаж сангийн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт шалгалт хийгээгүй, төлөөлөгчид сонирхсон үед нь холбогдох мэргэжилтнээс мэдээллийг гаргуулан авч мэйлээр явуулж байсан” гэсэн тайлбарыг өглөө.

Хэдийгээр аймгийн Засаг даргын зүгээс хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч байгаа боловч энэ нь сангийн хөрөнгийн нөхөн бүрдүүлэлтэд нөлөөлөхүйц үр дүнд хүрэхгүй байгаагаас Аймаг хөгжүүлэх сангийн нийт эх үүсвэрийн **90,2 хувь нь** хугацаа хэтэрсэн авлага хэлбэрт шилжсэн байна.

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Акт:

- Төлбөрийг буруу тооцож, зээлийг хаасан “Орхоны эрэг” ХХК-ийн 5,0 сая, иргэн А.Цэрэндолгорын 0,3 сая төгрөг зэрэг нийт 5,3 сая төгрөгийн хаагдсан үлдэгдлийг нөхөн төлүүлэх.
- Зээл төлөх хугацааг 2 удаа сунгасан хугацаа нь 2015 оны 9 сард дуусгавар болсон бөгөөд ашиглалтад оруулсан барилгын 87,3 хувийг борлуулсан Видү, Таванхан-Уул компаниудын хугацаа хэтэрсэн зээлийг нөхөн төлүүлэх-750,0 сая төгрөг зэрэг нийт **755,3** сая төгрөгийн акт тогтоогдов.

Албан шаардлага:

- Зээлийг тооцоо судалгаагүй, барьцаагүй олгосны улмаас хугацаа хэтэрсэн 3,342.3 сая төгрөгийн /нийт хугацаа хэтэрсэн зээлээс Видү, Таванхан –Уул компанийн зээлийг хассан / зээлийг нөхөн төлүүлж, төсвийг хохиролгүй болгох,

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Аймгийн ИТХТ-ээс баталсан журмаар зохицуулагдаж буй Аймаг хөгжүүлэх сан нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байна.
- Аймгийн ИТХТ-дийн зүгээс дуртай үедээ Аймаг хөгжүүлэх сангийн журамд өөрчлөлт оруулж, төсвийн цоорхойг нөхөх, дутагдсан урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болгон ашиглаж ирсэн байна.
- Орон сууцны хөрөнгө оруулалтын чиглэлээр олгосон зээл зориулалтын дагуу зарцуулагдсан бол жижиг дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр олгосон зээлийн 58,5 хувь нь зориулалт бусаар зарцуулагдсан байна.
- Зээлийг барьцаа хөрөнгөгүй, тооцоо судалгаагүй олгосны улмаас 54,1 хувьтай тэнцэх 4,092.3 сая төгрөгийн зээл гэрээт хугацаандаа төлөгдөөгүй байна.
- Аймгийн Засаг даргын зүгээс хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч байгаа боловч сангийн хөрөнгийн нөхөн бүрдүүлэлтэд нөлөөлөхүйц үр дүнд хүрэхгүй байна.
- Аймаг хөгжүүлэх сангийн нийт эх үүсвэрийн 90,2 хувь нь хугацаа хэтэрсэн авлага хэлбэрт шилжсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Бямбаад:

- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай болон Төсвийн тухай хуулийг зөрчиж боловсруулсан журмаар зохицуулагдаж буй Аймаг хөгжүүлэх санг татан буулгаж, эх үүсвэрийг ОНХС-д татан төвлөрүүлэх эсэх, эсвэл Сангийн яамнаас өгсөн зөвлөмжийн дагуу аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын төсөвт тусгай хөтөлбөр, зориулалтаар орлого, зарлагыг тусган төлөвлөж, тайлагнах эсэхийг судалж, оновчтой шийдвэрлэх.
- Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэр болж ашиглагдаж байгаа 4538,8 сая төгрөгийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайланг хэлэлцэж байх.

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

- Аймаг хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн 4092,3 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээ авах, шаардлагатай бол нэмэлт гэрээ байгуулж, үлдэгдлийг барагдуулах график гарган хэрэгжүүлэх.
- Сангийн хөрөнгийн эх үүсвэрээс тухайн жилийн төсөвт тусгаагдаж, батлагдаагүй хөрөнгө оруулалтын болон урсгал зардал гаргахгүй байх.

- *Аймаг хөгжүүлэх сангийн дансны зарлагын гүйлгээг аймгийн ИТХ-ын шийдвэр гартал түр хугацаагаар хаах.*

Аймаг хөгжүүлэх сангийн мэргэжилтэн 3.Загдсүрэнд:

- *Зээлийн үлдэгдэлтэй иргэд, аж ахуйн нэгжтэй тогтмол харилцаж, зээл төлүүлэх арга замыг тодорхойлох.*
- *Зээлийн эргэн төлөлтийн байдалд тогтмол хяналт тавьж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж байх.*
- *Иргэн Д.Энхтулгын зээлийн үлдэгдлийг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах.*

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Ц.ОТГОНБАЯР